MERIT
A CESO AND WUSC PROGRAM

МЕРИТ төслийн

Улирлын мэдээ

2018 оны 10-р сар | Сэтгүүл № 2



Оролцогчид харилцааны ур чадвар олгох сургалтын үеэр багаар ажиллах дасгал ажил хийв. Дундговь аймаг, 2018 оны 6-р сар

Сүхбаатар аймагт дрон ашиглах сургалт зохион байгуулав

2018 оны 7-р сарын 23-наас 8-р сарын 9

МЕРИТ төсөл Сүхбаатар аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтарч Улаанбаатар хот болон Дорнод, Сүхбаатар аймгийн байгаль орчны салбарын мэргэжилтнүүдэд зориулж дрон хэрхэн ашиглах талаар практик сургалт зохион байгууллаа. Сургалтанд оролцогчид дрон нислэгийн үндсэн зарчим болон аюулгүй ажиллагааг хангаж ажиллах, агаарын зураглал гаргах зориулалттай газарзүйн мэдээллийн QGIS системийг ашиглах талаар мэдлэг, мэдээллийг авсан.

Сургалтын үр дүнд оролцогчид цаашид аймаг, орон нутгийнхаа дэлгэрэнгүй газрын зураг гаргах, газар ашиглалтад гарч буй өөрчлөлтийг хянах, түүнчлэн газар ашиглалт, байгаль орчны менежментийн суурь мэдээллийг бүрдүүлэх боломжтой болж байна.

> *Дрон нисгэх эрхтэй болсноор бид байгаль орчинтой холбоотой шийдвэр гаргах явцад дрон ашиглаж үзлээ. Би МЕРИТ төслийн зохион байгуулсан сургалтаас олж авсан мэдлэгээ ашиглан "Төвийн бүсийн чуулга уулзалт"-нд байгаль орчины мэргэжилтэн, байцаагчдад сургалт хийсэн."*
>
> *БОАЖЯ-ны ахлах мэргэжилтэн М.Отгонтөгс*

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь туршлага судлах аялал зохион байгуулав

2018 оны 8-р сарын 5—8

МЕРИТ төсөлтэй хамтран ажилладаг төрийн байгууллагууд (УУХЯ, БОАЖЯ, АМГТГ)-ын болон Сүхбаатар, Дорнод, Төв, Дундговь аймгийн төлөөллүүд Ханбогд суманд туршлага судлах аялал зохион байгуулав.

Аяллын хүрээнд орон нутгийн захиргааны байгууллага болон уул уурхайн салбарын бизнес эрхлэгч, компани хоорондын хамтын ажиллагааны гэрээ байгуулах хэлэлцээр, гэрээний хэрэгжилт, үнэлгээний талаар тус сумын удирдлага, орон нутгийн иргэд, ханган нийлүүлэгчдийн төлөөлөлтэй уулзаж, санал солилцож, туршлага судлав. Мөн "Оюу толгой" ХХК-ийн үйл ажиллагааг үзэж, танилцлаа.



Ханбогд сумын засаг дарга туршлага судлах аяллын оролцогчдод хандан үг хэлэв, 2018 оны 8-р сар

Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвд Олон улсын хөдөлмөрийн байгууллагын мөрддөг Оролцоонд суурилсан жендэрийн аудитыг хийв


2018 оны 8-р сарын 20-ноос 9-р сарын 14

Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төвийн захирал Г.Номингийн санаачлагаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Оролцоонд суурилсан жендэрийн аудитыг МЕРИТ төсөлтэй хамтран хийв.

МЕРИТ төслийн дэмжлэгээр Г. Номин өнгөрсөн 6 дугаар сард Австри Улсын Вена хотод болсон НҮБ-ын Эмэгтэйчүүдийн байгуллагаас зохион байгуулдаг Жендэрийн тэгш байдал ба эмэгтэйчүүдийн эрхийн төлөөх манлайллын сургалт, хэлэлцүүлэгт хамрагдсан нь өөрийн байгууллагадаа тус аудитыг санаачлах санаа өгчээ.

Аудитыг хийхэд ОУХБ-ын жендэрийн аудиторын эрх бүхий Канад зөвлөхийн тусламжтайгаар байгууллагын бичиг баримтад дүн шинжилгээ хийж, семинар, ганцаарчилсан ярилцлагын аргуудыг хэрэглэсэн байна. Аудитаар төвийн үйл ажиллагааг жендэрийн өнцгөөс авч үзэх, байгууллагын ажлын бүх үе шатад жендэрийн тэгш байдлын үзэл баримтлалыг нэвтрүүлэх давуу болон сул талыг тодорхойлох ажлыг гүйцэтгэж, байгууллагын чадавхийг нэг шат ахиулсан гэж үзжээ.

Энэхүү аудитыг хийснээр байгууллагын түвшинд жендэрийн тэгш байдлын талаарх ойлголт, хандлага, үзэл баримтлалыг өөрчилж эхэлсэн байна.



Олон улсын хөдөлмөрийн байгууллагын мөрддөг Оролцоонд суурилсан жендэрийн аудитыг хийх явцад, 2018 оны 8-р сар

Канадын төрийн захиргааны институтийн хүрээнд 2018 оны төрийн албаны манлайллын хоёр дах симпозиумыг зохион байгуулав

2018 оны 9-р сарын 10—14

Олборлох салбарт төрийн байгууллагуудын хүний нөөцийн ур чадвар, төрийн албаны манлайллыг сайжруулах зорилгоор Канадын төрийн захиргааны хүрээлэн (IPAC)-тэй хамтран “Төрийн албаны шинэчлэлийг амжилттай удирдах нь: Орон нутгийн хамтран ажиллах гэрээ ” сэдэвт манлайллын симпозиумыг тус байгууллагын тэргүүн Доктор Роберт Тэйлор, Судалгаа, сурталчилгааны асуудал эрхэлсэн захирал Доктор Андреа Мигонэ нарын дэмжлэгтэйгээр зохион байгуулав.

Симпозиумд МЕРИТ төслийн хамтран ажиллагч төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагуудын удирдах ажилтнууд, ахлах мэргэжилтнүүд оролцов.

Энэхүү таван өдрийн сургалтаар төрийн албан хаагчдад шинэ санаа, санаачилга гаргах, өөрчлөлт шинэчлэлийн үйл явцыг удирдахад шаардлагатай мэдлэг, ур чадвар олгохыг зорив. Сургалтын явцад оролцогчид ашигт малтмал олборлогч компанитай хамтран ажиллах гэрээний талаар хэлэлцээр хийх практик дадлага хийж, туршлага солилцов.

Тухайлбал, Татварын ерөнхий газраас оролцсон ахлах мэргэжилтэн Канадын төрийн захиргааны байгууллагын туршлагаас суралцаж, шинэ практикийг хэрэгжүүлэх боломжтой болсондоо баяртай байна гэв.



Манлайллын симпозиумын үеэр оролцогчид багаар ажиллах дасгал хийв, 2018 оны 9-р сар

МЕРИТ төслийг Эрхүү хотод зохион байгуулсан олон улсын форумд онцлов

2018 оны 9-р сарын 20—21

МЕРИТ төслийн ахлах зөвлөх Ш.Оюунтуяа нь ОХУ-ын Эрхүү хотод 9 дүгээр сарын 20-21-ний өдөр болсон Байкалын олон улсын форумд судалгааны ажлаа танилцуулав.

Судалгааны ажлын сэдэв нь орон нутгийг хөгжүүлэх зорилгоор засгийн газар, иргэний нийгэм, орон нутгийн иргэд хамтран ажиллах олон улсын хөтөлбөрийг хэрэгжүүлэх Монгол Улсын туршлагын талаар байлаа.

Энэ судалгаанд Монголын уул уурхайн салбарын хариуцлагатай, тогтвортой хөгжлийг дэмжихэд МЕРИТ төслийн хүрээнд орон нутагт хэрэгжсэн шинэлэг хөтөлбөрүүдийг онцлов.

Түүнчлэн Канад Улс, дэлхийн дахины шилдэг туршлага дээр суурилан төрийн үйлчилгээний сүүлийн үеийн менежментийн практикийг хэлэлцлээ.

Дорнод аймагт “Уурхайн амьдралын мөчлөг”-ийн сэдвээр сургагч багш бэлтгэх семинар зохион байгуулав

2018 оны 9-р сарын 22-ноос 10-р сарын 13

Канад Улсын Нортвест Территорис мужийн Аурора коллежийн багш буюу МЕРИТ төслийн техникийн зөвлөх Майкл МакПерсон Дорнод их сургуультай хамтран "Уул уурхайн амьдралын мөчлөг"-ийн сургагч багшийг бэлтгэх сургалт зохион байгууллаа

Семинар нь уул уурхайн салбарын талаарх олон нийтийн ойлголтыг сайжруулах, Дорнод аймгийн дөрвөн сумд уурхайн амьдралын мөчлөгийн сургалт явуулахад Дорнод их сургуулийн Газрын тосны инженерийн тэнхимийн багш нарыг бэлтгэх зорилготой байлаа.

Дорнод их сургуулийн Газрын тосны инженерийн тэнхимийн багш нарт тус сургалтанд хамрагдаж, цаашид тус аймгийн дөрвөн сумын иргэдэд уул уурхайн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдлэг, мэдээлэл олгох чадавхтай боллоо. Түүнчлэн сургалтанд хамрагдсан багш нар Баяндун сумын иргэдэд Техникийн зөвлөхийн удирдлага дор хичээл зааж, дадлага хийлээ.

ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэн, МЕРИТ болон СЕСМИМ төслүүдийн хамтарсан мэдлэгийн портал олон нийтэд нээлттэй болов

2018 оны 10-р сарын 2



Мэдлэгийн порталын нээлтийн ажиллагааны үеэр ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн захирал, Доктор Д.Баттогтох үг хэлэв, 2018 оны 10-р сар

ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэн, Канадын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж буй МЕРИТ, СЕСМИМ төслийн хамтарсан мэдлэгийн портал олон нийтэд нээлттэй боллоо.

МЕРИТ болон СЕСМИМ төслүүдийн хүрээнд ШУА-ийн Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн бүх төрлийн мэдээ, мэдээлэл, судалгаа, шинжилгээний ажлын үр дүн олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй байх боломжийг бүрдүүллээ.

Мөн энэхүү портал нь дээрх хоёр төслийн үйл ажиллагааны хүрээнд англи, монгол хэл дээр боловсруулсан бүх төрлийн сургалтын материал, гарын авлага, сургалтын видео бүхий судалгааны мэдээлэл, тайлангийн нэгдсэн эх үүсвэр болж байна.

Мэдлэгийн порталын цахим хуудсууд:
www.portal.igg.ac.mn
www.portal.merit.mn
www.portal.sesmim.mn

Эдгээр мэдээлэл ил тод, хүртээмжтэй болсноор олборлох салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэхэд дэмжлэг болоод зогсохгүй уул уурхай, эрдэс баялгийн салбарын хөгжлөөрөө тэргүүлэгч орнуудын нэг Канад Улсын туршлагаас суралцах боломж бүрдэж байна.

> *“Бид мэдлэгийн порталаар дамжуулан шинэ санаа, инновацийг дэмжин ажиллах болно. Манай порталын хэрэглэгчид Шинэлэг бөгөөд инноваци бүхий судалгааны ажлыг уншиж, дүн шинжилгээ хийх замаар судалгаа, шинжилгээний ажлыг амьдралд нэвтрүүлэх боломжийг олж харах юм.“*
>
> *Доктор Д. Баттогтох, Газарзүй-геоэкологийн хүрээлэнгийн захирал*


FROM POLICY MAKER TO *Change Maker:* FORMER CANADIAN GOVERNMENT EXECUTIVES VOLUNTEER FOR SUSTAINABLE DEVELOPMENT

Bryan Marshman

Darren Schemmer

Brenda Boucher

From research to policy implementation, Canadian public servants possess the knowledge and expertise that have shaped and strengthened the country's socioeconomic landscape. In this article, we look at the tremendous impact of former high-level government officials who decided to share their expertise and knowledge as volunteers.

With over 10 years of experience of working in Canada and abroad, the Canadian Executive Service Organization (CESO) knows that developing a strong economic infrastructure leads to sustainable change that works for everyone. The organization works with local partners to strengthen their capacity to create an equitable environment for the private sector to thrive and contribute to inclusive growth. "Our volunteers are highly skilled and are passionate about sharing a lifetime of experience," explains Wendy Hortin (CESO CEO and President). They equip partners with the skills, experience and confidence to reach their objectives, grow their businesses and develop their communities in a sustainable manner.

We spoke with three retired Canadian government executives who chose to become CESO volunteers and feel encouraged to share their years of experience. They talked to us about their motivation, experience and learning as a volunteer.

First, tell us about your professional background, specifically your work as a Canadian public servant.

Bryan Marshman: I am a professional accountant (FCPA, FCGA). Most of my career has been with the Canada Revenue Authority (CRA). I was working in the compliance department in Toronto offices for 28 years. I also worked in the head office in Ottawa as a manager with the International Tax Directorate (ITD).

Darren Schemmer: I spent 25 years in the Canadian public and foreign services. I was posted abroad to Honduras, the Organization of American States, Egypt and as High Commissioner to Ghana. At the Global Affairs headquarters, I held many positions including Director General of the Centre for Partnerships for Development.

Brenda Boucher: I retired. I served as a public servant for 38 years with the provincial government of New Brunswick where I held a number of roles including Director of Policy, Deputy Minister and Secretary to Cabinet because as Assistant Deputy Minister in the Premier's Office and served as a liaison with New Brunswick's 15 First Nations.

You're still currently active volunteers with CESO. Can you tell us your own motivation in becoming a volunteer? Why CESO?

Bryan: Before I retired, I read an article about Canadians volunteering abroad. The article made me realize how rewarding volunteering could be. I had been provided with a very significant amount of training and knowledge throughout my career. I felt that I should share my experiences. So, CESO's model and mandate gave me an opportunity to give back in a way that fits my lifestyle.

Darren: I have volunteered throughout my life and wanted to continue to do so. CESO suits me as a retiree, and I believe in the mission of creating stronger economies and better lives.

Brenda: Volunteering has been part of my personal fabric since I was a young professional. I was initially drawn to assignment opportunities with Indigenous Communities in northern Canada. The MERIT project in Mongolia also looked particularly intriguing, and although not in the Arctic, Mongolia is a country that has found a special place in my heart. My assignments in Mongolia have been extremely rewarding personally, and have afforded me the opportunity to give back by sharing some of my experiences and knowledge from my many years as a public servant in New Brunswick.

How have your experiences as a volunteer enriched your life?

Bryan: Meeting, speaking with, and sharing knowledge with CESO clients and partners around the globe and here at home is extremely rewarding. For me, it is the most rewarding aspect of volunteering. I am at a CESO volunteer in countries such as the Ukraine, China, Guyana, Honduras, Vietnam, and Tanzania where I have the opportunity to experience their culture and see things their way, while working with them to improve their community and businesses.

Darren: This is hard to answer because sometimes you don't realize a benefit until much later. An idea you were exposed to, a skill you learned, a person you met, can suddenly open an unexpected opportunity. Volunteering has also helped to reset my priorities, to reconnect with what matters the most, challenges, and to work on them together, is very rewarding. Ultimately, I believe I learn as much as I share.

Brenda: My experiences with CESO have left me with an overwhelming feeling of gratitude as a Canadian. I am proud of Canada's development assistance and the opportunity, through CESO, to share my experiences and knowledge with other countries.

Why should other Canadian government executives share their experience and expertise?

Bryan: If you have spent your whole life serving the Canadian public, then you have far more knowledge and know-how than you can imagine. I would ask you to consider sharing this knowledge with others.

Darren: The Canadian public service is one of the best in the world. Many countries are interested in learning how we craft policy, design services and deliver programs. They want to learn from us and want to know how we maintain an impartial professional public service across many years of governments.

Brenda: The Canadian experience in the public sector in general, and at the executive level in particular, is a privilege that can help enrich and inform those in other countries.

Share your skills and expertise

Your skills and expertise as a Canadian government executive can make a difference. I for Bryan, Darren and Brenda, you should consider volunteering if you have:

- Strong governance and public institutions are key to creating an equitable environment for individuals and communities to prosper. Last year, CESO volunteers completed over 130 assignments with 46 governmental and community organizations. Your experience in governance issues can help catalyze innovative and collaborative solutions to local challenges, including poverty reduction, in countries around the world.
- CESO is actively looking for senior-level professionals with a variety of expertise, including government and public sector management as well as technical and leadership proficiency, to fill short-term assignments of approximately two to four weeks in our program countries.

If you have more than 10 years of professional experience and are looking for a meaningful way to share your skills, consider becoming a CESO Volunteer Advisor.

To learn more about how to become a CESO Volunteer Advisor, visit our website: www.ceso-saco.com/volunteer

Quinn Gruchy, Director, Communications and Engagement – CESO

Канад Улсын Засгийн газрын "Удирдах ажилтан"-ы сэтгүүлд МЕРИТ төслийн техникийн зөвлөхийг онцлов

2018 оны 7-р сар

Канад Улсын Засгийн газраас эрхлэн гаргадаг сэтгүүлээс Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллагад техникийн зөвлөхөөр ажиллаж, өөрсдийн олон жилийн туршлагаа бусадтай хуваалцаж байгаа чин хүсэлтэй Канадын Засгийн газрын удирдах албан тушаал хашиж байсан гурван хүнийг онцоллоо.

Тэдний дунд 2017-2018 онд Монгол Улсад үр дүнд суурилсан төлөвлөлт хийх арга зүйн талаар олон удаагийн сургалт явуулсан МЕРИТ төслийн техникийн зөвлөх Брэнда Боучер багтсан юм.

Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллагад сайн дурын техникийн зөвлөхөөр ажилллах үедээ Боучер Дорнод аймаг болон 14 сумдын Засаг даргын тамгын газарт зөвлөх, ментор хийснээр тухайн орон нутгийн тогтвортой хөгжилд өөрийн хувь нэмрээ оруулжээ.

> *Сайн дурын ажил бол миний амьдралын нэгээхэн хэсэг юм. […] Монгол Улсад хийсэн сургалт маань надад маш их таалагдсан бөгөөд Канадын Нью Брансвик мужид олон жил төрийн алба хашсан туршлага, мэдлэгээ бусадтай хуваалцах боломж олдсонд би туйлын баяртай байна."*
>
> *Брэнда Боучер, МЕРИТ төслийн техникийн зөвлөх*

МЕРИТ төслийн түншүүд Төв аймгийн Заамар сумын байгаль орчны менежментийн шилдэг туршлагатай танилцав

2018 оны 9-р сарын 18—19

Заамар суманд хийсэн туршлага судлах аяллаар МЕРИТ төслийн хамтрагч яамд, нутгийн захиргааны байгууллагуудын төлөөлөл, байгаль орчны байцаагчдаас бүрдсэн нийт 45 оролцогч "Уул уурхайн үндэсний олборлогч" ММО ХХК-ийн биологийн нөхөн сэргээлтийн шилдэг туршлагатай танилцав.

Мөн орон нутгийн засаг захиргаа, ашигт малтмал олборлогчид болон иргэдийн хамтын ажиллагаанд суурилсан байгаль орчны менежментийн шилдэг туршлагыг судлав.



Заамар суманд уурхайн нөхөн сэргээлтийн талбайтай танилцлаа, 2018 оны 9-р сар

МЕРИТ төслийн тухай

"Монгол Улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь" төсөл нь (МЕРИТ) Канадын Гадаад харилцааны яамнаас санхүүжилттэй, долоон жилийн хугацаанд (2016—2023) хэрэгжих юм.

МЕРИТ нь Канадын хоёр төрийн бус байгууллага, Канадын мэргэжлийн үйлчилгээний байгууллага (CESO) болон Канадын дэлхийн их сургуулийн үйлчилгээ (WUSC) хоорондын түншлэлээр, олборлох салбарыг үр дүнтэй удирдах төрийн байгууллагуудын арга барилыг чадавхжуулснаар Монгол дахь тогтвортой эдийн засгийн өсөлтийг дэмжих зорилготой юм.

БИДЭНТЭЙ ХОЛБОО БАРИХ

Монгол Улс, Улаанбаатар-15160
Чингэлтэй дүүрэг, 1-р хороо,
Худалдааны гудамж,
Нейшнл Таймс Нюсь Тауэр,
3-р давхар

info@merit.mn
www.merit.mn
+976 7016 5000

Global Affairs Canada
Affaires mondiales Canada
CESO SACO STRONGER ECONOMIES. BETTER LIVES.
WUSC EUMC Education changes the world • L'éducation change le monde